

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/65/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Аудитор: Б.Одгэрэл
Утас: 70453721, Цахим хаяг: Odgerelb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	15
3.8 Аудитын гол асуудал	15
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
4. Аудитын илрүүлэлт	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.04.25 № УВА-2022/65/НА-СТА-ТШЗ

танай _____ -ны № _____ -т

МАЛЧИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
Ш.БАТТУЛГА ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М.БАТСУУРЬ

0200200301

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,854,986.00</u>	<u>1,778,840.00</u>
335	Бусад авлага	00.00	800,000.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	800,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,854,986.00	978,840.00
354	Хангамжийн материал	2,854,986.00	978,840.00
35410	Бичиг хэргийн материал	91,500.00	91,500.00
35420	Аж ахуйн материал	2,763,486.00	887,340.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,139,768,655.46</u>	<u>1,058,893,638.55</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,139,768,655.46	1,058,893,638.55
392	Биет хөрөнгө	1,100,176,155.46	1,024,019,138.55
39201	Барилга, байгууламж, орон сууц	980,455,500.00	1,007,920,220.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-150,730,193.47	-218,084,787.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	219,523,890.00	66,614,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-56,060,590.00	-18,790,188.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	62,129,883.00	57,839,883.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-30,229,947.43	-32,396,728.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,995,864.77	67,264,526.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-35,673,787.07	-39,161,011.96
39209	Зам, гүүрийн байгууламж	42,565,484.00	92,565,484.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-10,641,370.95	-19,154,467.71
39214	Бусад үндсэн хөрөнгө	33,434,140.00	40,434,140.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,667,547.39	-11,087,559.93
39216	Дуусаагүй барилга, байгууламж	00.00	29,980,000.00
39217	Ном	74,830.00	74,830.00
393	Биет бус хөрөнгө	39,592,500.00	34,874,500.00
39301	Програм хангамж	2,355,000.00	2,355,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,792,500.00	-1,942,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	39,030,000.00	34,462,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,142,623,641.46</u>	<u>1,060,672,478.55</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>800,000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	800,000.00
413	Өглөг	00.00	800,000.00
4136	Бусад өглөг	00.00	800,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	800,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,142,623,641.46</u>	<u>1,059,872,478.55</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,142,623,641.46	1,059,872,478.55
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	426,363,182.17	426,363,182.17
51101	Өмч: - төрийн	426,363,182.17	426,363,182.17
512	Хуримтлагдсан үр дүн	213,040,615.31	130,320,701.80
51210	Өмнөх үеийн үр дүн	213,040,615.31	213,071,864.71
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-82,751,162.91
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	503,219,843.98	503,188,594.58
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,142,623,641.46</u>	<u>1,060,672,478.55</u>

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	658,511,960.00	609,143,230.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	264,396,380.00	94,937,960.00
120	Нийтлэг татварын бус орлого	264,396,380.00	94,937,960.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	264,396,380.00	94,937,960.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,383,360.00	552,960.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	263,013,020.00	94,385,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	394,115,580.00	514,205,270.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,487,480.00	145,239,170.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,500,000.00	12,057,250.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,430,000.00	130,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	557,480.00	2,381,920.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	374,628,100.00	368,966,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	374,628,100.00	368,966,100.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	505,104,696.35	526,921,992.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	505,104,696.35	526,921,992.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	494,727,676.35	511,230,791.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	235,519,321.00	246,710,529.15
210101	Үндсэн цалин	207,447,495.00	212,959,986.15
210105	Гэрээт ажлын хөлс	28,071,826.00	33,750,543.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,131,432.00	32,420,832.00
210201	Тэтгэврийн даатгал	20,559,086.00	22,516,401.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,410,197.00	2,495,329.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,927,736.00	1,982,823.35
210204	Ажилгүйдлийн даатгал	479,940.00	502,461.75
210205	Эрүүл мэндийн даатгал	6,754,473.00	4,923,815.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,219,325.00	25,050,233.46
210301	Гэрэл, цахилгаан	3,486,325.00	3,589,926.00
210302	Түлш, халаалт	18,639,900.00	21,328,307.46
210303	Цэвэр, бохир ус	93,100.00	132,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	33,444,140.00	23,193,923.00
210401	Бичиг хэрэг	4,190,400.00	3,785,250.00
210402	Тээвэр, шатахуун	22,536,045.00	13,568,727.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,060,000.00	2,540,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	166,600.00

Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,457,695.00	3,133,346.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,099,000.00	3,720,200.00
210604	Урсгал засвар	6,099,000.00	3,720,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,546,000.00	4,065,000.00
210702	Дотоод албан томилолт	1,546,000.00	4,065,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,413,347.00	2,582,007.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,266,364.00	874,723.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.00	170,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	53,500.00	277,784.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	525,500.00	688,500.00
210807	Газрын төлбөр	311,458.00	239,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	152,355,111.35	173,488,066.91
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,484,640.00	26,410,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,400,000.00	1,390,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	126,470,471.35	145,687,616.91
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,377,020.00	15,691,201.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,430,000.00	12,482,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	11,653,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,430,000.00	829,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,947,020.00	3,208,801.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,947,020.00	3,208,801.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>153,407,263.65</u>	<u>82,221,237.09</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	59,385,133.71	164,972,400.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	51,041,666.76	164,972,400.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	8,343,466.95	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-59,385,133.71	-164,972,400.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>94,022,129.94</u>	<u>-82,751,162.91</u>

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	395,734,440.00	514,758,230.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,383,360.00	552,960.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,383,360.00	552,960.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,383,360.00	552,960.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,383,360.00	552,960.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	394,351,080.00	514,205,270.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,487,480.00	145,239,170.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,500,000.00	12,057,250.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,430,000.00	130,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	557,480.00	2,381,920.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	800,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	374,863,600.00	368,966,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	374,863,600.00	368,966,100.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	395,734,440.00	384,758,230.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	395,734,440.00	384,758,230.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	385,357,420.00	369,067,028.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,395,124.00	246,710,529.15
210101	Үндсэн цалин	204,362,324.00	212,959,986.15
210105	Гэрээт ажлын хөлс	34,032,800.00	33,750,543.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,171,539.00	32,420,832.00
210201	Тэтгэврийн даатгал	20,559,086.00	22,516,401.54
210202	Тэтгэмжийн даатгал	2,410,197.00	2,495,329.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,927,736.00	1,982,823.35
210204	Ажилгүйдлийн даатгал	479,940.00	502,461.75
210205	Эрүүл мэндийн даатгал	4,794,580.00	4,923,815.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,219,325.00	25,050,233.46
210301	Гэрэл, цахилгаан	3,486,325.00	3,589,926.00
210302	Түлш, халаалт	18,639,900.00	21,328,307.46
210303	Цэвэр, бохир ус	93,100.00	132,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,774,885.00	20,715,377.00
210401	Бичиг хэрэг	4,190,400.00	3,785,250.00
210402	Тээвэр, шатахуун	19,890,485.00	13,568,727.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,060,000.00	2,540,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	166,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,434,000.00	654,800.00

Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2105	Нормативт зардал	447,000.00	372,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	447,000.00	372,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,268,500.00	5,720,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,169,500.00	00.00
210602	Тавилга	3,000,000.00	2,000,000.00
210604	Урсгал засвар	6,099,000.00	3,720,200.00
2107	Томилолт, зочны зардал	1,546,000.00	4,065,000.00
210702	Дотоод албан томилолт	1,546,000.00	4,065,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,413,347.00	2,582,007.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,266,364.00	874,723.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	288,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	96,525.00	170,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	53,500.00	277,784.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	00.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	525,500.00	688,500.00
210807	Газрын төлбөр	311,458.00	239,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,121,700.00	31,430,450.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,630,200.00	30,040,450.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,491,500.00	1,390,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,377,020.00	15,691,201.39
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,430,000.00	12,482,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	11,653,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,430,000.00	829,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	5,947,020.00	3,208,801.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,947,020.00	3,208,801.39
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	130,000,000.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	130,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	130,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	130,000,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	130,000,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-130,000,000.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	387,333,182.17	2,118,704.76	194,552,318.65	584,004,205.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	387,333,182.17	2,118,704.76	194,552,318.65	584,004,205.58
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-13,375,987.09	-13,375,987.09
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	426,363,182.17	503,219,843.98	213,040,615.31	1,142,623,641.46
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	426,363,182.17	503,219,843.98	213,040,615.31	1,142,623,641.46
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	31,249.40	31,249.40
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	426,363,182.17	503,219,843.98	213,071,864.71	1,142,654,890.86
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-31,249.40	00.00	-31,249.40
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-82,751,162.91	-82,751,162.91
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	426,363,182.17	503,188,594.58	130,320,701.80	1,059,872,478.55

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	368,966,100.00	367,110,258.61	1,855,841.39	99.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	368,966,100.00	367,110,258.61	1,855,841.39	99.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	356,479,700.00	354,627,858.61	1,851,841.39	99.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	247,206,000.00	246,710,529.15	495,470.85	99.80
210101	Үндсэн цалин	213,173,200.00	212,959,986.15	213,213.85	99.90
210105	Гэрээт ажлын хөлс	34,032,800.00	33,750,543.00	282,257.00	99.17
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,372,700.00	32,420,832.00	951,868.00	97.15
210201	Тэтгэврийн даатгал	23,484,500.00	22,516,401.54	968,098.46	95.88
210202	Тэтгэмжийн даатгал	2,472,100.00	2,495,329.40	-23,229.40	100.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,977,600.00	1,982,823.35	-5,223.35	100.26
210204	Ажилгүйдлийн даатгал	494,400.00	502,461.75	-8,061.75	101.63
210205	Эрүүл мэндийн даатгал	4,944,100.00	4,923,815.96	20,284.04	99.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,123,200.00	25,050,233.46	72,966.54	99.71
210301	Гэрэл, цахилгаан	3,591,800.00	3,589,926.00	1,874.00	99.95
210302	Түлш, халаалт	21,351,400.00	21,328,307.46	23,092.54	99.89
210303	Цэвэр, бохир ус	180,000.00	132,000.00	48,000.00	73.33
2104	Хангамж, бараа материалын зардал	20,109,800.00	20,108,180.00	1,620.00	99.99
210401	Бичиг хэрэг	3,689,800.00	3,785,250.00	-95,450.00	102.59
210402	Тээвэр, шатахуун	12,959,100.00	12,961,530.00	-2,430.00	100.02
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,548,400.00	2,540,000.00	8,400.00	99.67
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	166,600.00	166,600.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	745,900.00	654,800.00	91,100.00	87.79
2105	Нормативт зардал	372,400.00	372,400.00	0.00	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	372,400.00	372,400.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,720,200.00	5,720,200.00	0.00	100.00
210602	Тавилга	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	3,720,200.00	3,720,200.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	4,138,400.00	4,065,000.00	73,400.00	98.23
210702	Дотоод албан томилолт	4,138,400.00	4,065,000.00	73,400.00	98.23
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,187,300.00	1,957,284.00	230,016.00	89.48

Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,000.00	250,000.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	288,000.00	115,200.00	71.43
210803	Даатгалын үйлчилгээ	242,000.00	170,000.00	72,000.00	70.25
210804	Тээврийн хэрэгслийн татвар	290,600.00	277,784.00	12,816.00	95.59
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	74,000.00	44,000.00	30,000.00	59.46
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	688,500.00	688,500.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	239,000.00	239,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18249700.00	18223200.00	26,500.00	99.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,833,200.00	16,833,200.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,416,500.00	1,390,000.00	26,500.00	98.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12486400.00	12482400.00	4,000.00	99.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	12,486,400.00	12,482,400.00	4,000.00	99.97
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,400.00	11,653,400.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	833,000.00	829,000.00	4,000.00	99.52
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	368,966,100.00	367,110,258.61	1,855,841.39	99.50
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	368,966,100.00	366,557,298.61	2,408,801.39	99.35
132001	Орон нутгийн төсвөөс	368,966,100.00	366,557,298.61	2,408,801.39	99.35
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	552,960.00	-552,960.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	552,960.00	-552,960.00	

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		14,439,170.00	-14,439,170.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ		14,439,170.00	-14,439,170.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		14,439,170.00	-14,439,170.00	
2104	Хангамж, бараа материалын зардал		607,197.00	-607,197.00	
210402	Тээвэр, шатахуун		607,197.00	-607,197.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		624,723.00	-624,723.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		624,723.00	-624,723.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		13207250.00	-13,207,250.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		13,207,250.00	-13,207,250.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		130,000,000.00	-130,000,000.00	
2200	Дотоод эх үүсвэрээр		130,000,000.00	-130,000,000.00	
223001	Бусад хөрөнгө		130,000,000.00	-130,000,000.00	
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		144439170.00	-144,439,170.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		144,439,170.00	-144,439,170.00	
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		12,057,250.00	-12,057,250.00	
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		130,000,000.00	-130,000,000.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,381,920.00	-2,381,920.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, Дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Малчин сумын Засаг даргын тамгын газар нь Засгийн газар болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийх, үр дүнг үнэлж дүгнэх, удирдлагыг цаг үеэ олсон зөвлөгөө, бүх талын үйлчилгээ, мэдээллээр хангах, төрийн үйлчилгээг иргэдэд чанартай хүртээмжтэй хүргэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 564,489.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,515.9 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 526,922.0 мянган төгрөгийн 1 хувиар буюу 5,269.2 мянган төгрөгийн 80 хувиар тооцож 4,215.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 81,951.1 мянган төгрөгөөр буюу 7.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өт төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	0.0	800.0	800.0
Бараа материал	2,855.0	978.8	-1,876.2
Үндсэн хөрөнгө	1,139,768.7	1,058,893.6	-80,875.1
Нийт хөрөнгө	1,142,623.6	1,060,672.5	-81,951.1
Өр төлбөр	0.0	800.0	800.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,142,623.6	1,059,872.5	-81,151.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,142,623.6	1,060,672.5	-81,951.1

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 800.0 мянган төгрөг болж 800.0 мянган төгрөгөөр өссөн тайлант онд төрөөс тогтмол зардлын хөнгөлөлтийг ковид-19 цар тахалтай холбоотой үзүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 978.8 мянган төгрөг болж 1,876.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд аж ахуйн материал акталснаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,058,893.6 мянган төгрөг болж 80,875.1 мянган төгрөгөөр буурсан нь хандиваар хүлээн авсан 171,240.0 мянга, балансаас баланст шилжүүлэн авсан 23,000.0 мянга, төсвийн хөрөнгөөр 35,400.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдэж, тайлант онд 145,687.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсон, 252,962.4 мянган төгрөгийн хөрөнгө балансаас баланст шилжүүлж, 9,876.3 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,059,872.5 мянган төгрөг болж 81,151.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 49,368.7 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 21,817.3 мянган төгрөгөөр буюу 4.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан цалин, байр ашиглалттай холбоотой зардал, бараа үйлчилгээний бусад зардал байна. Энэ нь түлш халаалтын тариф өссөн, тайлант оны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Өглөг дансны үлдэгдэл 800.0 мянган төгрөг болж 800.0 мянган төгрөгөөр өссөн тайлант онд төрөөс тогтмол зардлын хөнгөлөлтийг ковид-19 цар тахалтай холбоотой үзүүлсэнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Малчин сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 402,974.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 329,561.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 34,008.5 мянган төгрөгөөр бууруулж 368,966.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хангамж бараа материалын зардал, бараа үйлчилгээний бусад зардлын төсвийг бууруулж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 368,966.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 368,966.1 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 368,966.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 553.0 мянган төгрөг оруулж, нийт 369,519.1 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 367,110.3 мянган төгрөгийг зарцуулж 3,208.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 367,110.3 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Малчин сумын Засаг даргын тамгын газрын нэмэлт санхүүжилтийн дансаар 14,439.82мянган төгрөгийн орлого орж 14,439.2 мянган төгрөгийн зарлага гарсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Малчин сумын Засаг даргын тамгын газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, мэдээлэх хугацаа болоогүй 2 мэдээлэл хүлээгдэж байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны албан шаардлага өгснийг хэрэгжүүлж, биелэлтийг гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Засаг даргын 2021 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн А/43 дугаар захирамжаар сумдын Засаг даргын тамгын газрын, багийн бүтэц орон тоог батлахдаа гэрээт ажилтны орон тоог батлаагүй байна. Дараагийн аудитаар энэ асуудлыг анхаарч шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Малчин сумын Засаг даргын тамгын газар	-	-	-	-	-	-	-	-	-	-
ДҮН											

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  /Б.ОДГЭРЭЛ/

2022 оны 02 сарын 25-ны өдөр